

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРТЭЙ

БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Аймгийн Засаг дарга 2009 онд ерөнхий менежертэй удирдлага, зохион байгуулалт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ үнэлгээ, нутгийн захиргааны байгууллагуудтай ажиллах зэрэг 9 бүлэг асуудал, 110 заалт бүхий үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан байна.

Үр дүнгийн гэрээний заалт нэг бүрийн хэрэгжилтийг нарийвчлан тооцож үзэхэд 100% биелүүлсэн байна. Ерөнхий менежер нь үр дүнгийн гэрээний биелэлтийн явц байдлыг улирал тутам аймгийн Засаг даргад танилцуулан үр дүнг тооцож, тасарч яваа болон хэрэгжилт нь удаашралтай байгаа заалтуудыг нөхөн биелүүлэх арга хэмжээ авч байжээ.

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар:

Ерөнхий менежер нь 2009 онд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг биелүүлэх ажлыг эрчимжүүлэх, өвөлжилтийн бэлтгэлийг хангах, орон нутагт хэрэгжүүлж байгаа үндэсний төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнг дээшлүүлэх тухай болон цаг үеийн бусад асуудлаар 483 захирамжийн төсөл боловсруулан батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Тайлангийн хугацаанд Засгийн газрын 142 шийдвэрийн 200 заалтыг хяналтанд авч 92,0 хувиар биелүүлсэн байна. 2009 онд ерөнхий менежер гэрээнд заасан үүргийнхээ дагуу нийт сумдын Засаг дарга, хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд, нийгмийн ажилтнууд, жижиг дунд үйлдвэр эрхлэгчид, сум, албан байгууллагын архив бичиг хэргийн эрхлэгчдийн зэрэг аймгийн хэмжээний 8 удаагийн зөвлөлгөөн, сургалт семинарыг зохион байгуулжээ.

Мөн энэ хугацаанд аймгийн 2010-2020 оны хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж батлуулсны дээр аймаг, сумдын ЗДТГ-ын хөдөлмөрийн дотоод журам, төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг бүрэн шинэчилж тэдгээрийг Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулах асуудлыг шийлвэрлэжээ.

2009 онд нийт 13 суманд аймгийн ЗДТГ-ын ажлын хэсгийг томилон ажиллуулж, цаг үеийн ажлыг зохион байгуулахад туслахын зэрэгцээ Баяннуур, Ногооннуур, Алтанцөгц сумын Засаг дарга, ЗДТГ-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн үүрэг даалгавар өгчээ.

Аймгийн ЗДТГазар 2009 онд нийт сум, төсөвт албан байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор тэдний ажлыг Засгийн газрын 2009 оны 143-р тогтоолоор баталсан ил тод байдлын 4 үндсэн үзүүлэлтээр дүгнэн нийтэд ил тод зарладаг, төрийн үйлчилгээний байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулдаг, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагийн дарга нарын мэдээллийг 7 хоног бүрийн баасан гаригт сонсож олон нийтэд мэдээлдэг, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Боловсрол соёлын газар, Мэргэжлийн хяналтын газар зэрэг төрийн үйлчилгээний байгууллагуудын тайланг олон нийтээр хэлэлцүүлэн үнэлэлт дүгнэлт өгүүлдэг зэрэг арга барилыг хэвшүүлжээ.

Хоёр.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг

хэрэгжүүлэх талаар

Үр дүнгийн гэрээнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар 25 асуудал тусгаж бүрэн биелүүлсэн байна.

Энэ хугацаанд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, түүнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлжүүлэх асуудал эрхэлсэн комисс байгуулан үйл ажиллагаанд нь хяналт тавихын зэрэгцээ ажил олгогч эздийн аймгийн зөвлөлгөөн, нөхөн үржихүйн асуудал эрхэлсэн эмч, мэргэжилтэн, шийдвэр гаргагчдын хамтарсан уулзалт зохион байгуулж, Тэргүүний ажил олгогчдыг шалгаруулах болзол, эх нялхаст ээлтэй сум, байгууллага шалгаруулах болзол зарлан дүгнэсэн нь ихээхэн ач тустай боллоо.

Аймгийн ЗДТГ-ын удирдлага дэмжлэгтэйгээр 2009 онд дараахь бүтээлч ажлууд хийгдлээ. Үүнд:

1.Орон нутгийн төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлэх, төсвийн зарцуулалтанд тавих хяналтыг эрс сайжруулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлж ажиллалаа. 2009 онд үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөж, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажлын үр дүнд татвар төлөгчдийн бааз суурь нэмэгдэж орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлэх боломж бүрдлээ.

2009 онд төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөөг 229,0 сая төгрөгөөр буюу 45 хувиар, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 658,0 сая төгрөгөөр буюу 32,3 хувиар давуулан биелүүллээ.

Санхүү, эдийн засгийн хямрал хүндрэлтэй холбогдон төсөвт байгууллагуудад үүссэн өр, зээлийн асуудлыг нарийвчлан судалж Сангийн яаманд танилцуулж хөөцөлдсөний үр дүнд өр барагдуулах журмаар төсвийг нэмэгдүүлж, энэ онд өргүй гарах боломж бүрдүүлж чадсан нь гол зүйл гэж үзэж байна.

2009 онд Булган, Ногооннуураас бусад сумдыг төрийн сангийн сүлжээнд холбож, сумдын төрийн сангийн төлөөлөгчдийг бие даасан орон тоогоор ажиллуулж эхэлснээр төсвийн зарцуулалтанд өдөр тутам хяналт тавих бололцоо бүрдсэн болно.

2.Улаанхус сумын Согоогийн баг, Цагааннуур-Улаанбайшинтын чиглэлийн 10 кВт-ын болон Өлгий-Цагааннуур-Ногооннуур сумыг холбосон 35 кВт-ын ЦДАШ-ыг дэд станцын хамт барьж ашиглалтанд оруулсны дээр Ховдын Дуутаас Өлгийн Булган сум хүртэлх 15 кВт-ын 109 км ЦДАШ-ын 1,3 тэрбум төгрөгийн төсөвтэй барилгын үндсэн ажлыг хийж, ирэх оны эхний хагаст багтаан ашиглалтанд авахад бэлэн болсноор аймгийн нийт сумдыг баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн системд бүрэн холбох томоохон зорилтыг шийдвэрлэх боломж бүрдэж байна.

3.2009 онд аймгийн хэмжээний дэд бүтэц, зам, гүүр барилгын салбарт 2,15 тэрбум төгрөгийн ажил хийгдсэний дотор Сагсай сумын Турганы гол дахь бетон гүүрийн барилгын ажлыг дуусгаж, Улаанхус сумын 181,8-ийн урттай томоохон бетон гүүрийг 2010 онд ашиглалтанд оруулах боломж бүрдлээ.

Өнгөрсөн онд Булган сумын Булган гол, Дэлүүн сумын Ганц модны гол, Алтай сумын Сагсайн голуудад нийт 83 урт метр модон гүүрийг орон нутгийн замын сангийн хөрөнгөөр шинээр барилаа. Түүнчлэн 2009 онд Өлгий-Цагааннуурын хатуу хучилттай 30 км замыг үргэлжлүүлэн барих 13 тэрбум төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлж, гүйцэтгэгчийг нь тодруулан газар шорооны ажлыг эхлүүлснээр энэ замыг 2011 онд багтаан дуусгах боломжтой боллоо. Баруун бүсийн автозамыг хөгжүүлэх төслийн хүрээнд Өлгий-Хашаатын чиглэлийн хатуу

хучилттай автозамыг БНХАУ-ын 50.0 сая ам долларын хөнгөлөлттэй зээлээр барихаар шийдвэрлээд байна.

Энэ салбарт хийгдэж байгаа бас нэг томоохон ажил бол Өлгий хотын Нисэх буудлын 11,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй хатуу хучилттай зурвас, 1,7 тэрбум төгрөгийн өртөгтэй спорт цогцолборын барилгын ажил идэвхтэй явагдаж, баруун бүс нутагт томоохонд тооцогдох энэ хоёр объектыг ирэх онд ашиглалтанд оруулахаар шамдан ажиллаж байгаа явдал юм.

4.2009 онд үйлдвэрлэлийг дэмжих жилийн ажлын хүрээнд улсын төсвөөс олгосон 763,0 сая төгрөгийг хүнс, ХАА-н үйлдвэрлэл, хөнгөн болон барилгын материалын үйлдвэр, эм бэлдмэл, ахуйн болон худалдаа үйлчилгээ гэсэн 8 үндсэн чиглэлээр төсөл шалгаруулан 83 аж ахуйн нэгжийг хамруулан хөнгөлөлттэй нөхцлөөр зээлжүүлснээр 361 иргэн ажилтай, орлоготой болох нөхцөл бүрдлээ.

5. Дэлхийн банкны төслөөр Өлгий хотын гэр хорооллын цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулан алдагдлыг бууруулах 2,1 тэрбум төгрөгийн өртөгтэй ажлыг хийж дуусгалаа.

Өлгий хотын дулааны зуухын тоног төхөөрөмжийг шинэчлэх ойрын болон дунд хугацааны төслийг бэлэн болгож, Эрдэс баялаг эрчим хүчний яамтай хамтран хэрэгжүүлэхээр идэвхтэй ажиллаж байна.

Аймаг байгуулагдсан 70 жилийн ой угтаж Өлгий хотын авто замын болон явган хүний замыг засварлах, шинэчлэн сайжруулах 1,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг эхлүүлснээр олон хүнийг ажилтай болгох, хотын өнгө төрхийг сайжруулахад үр дүнгээ өгнө.

2008, 2009 онд Өлгий хотын дулааны үйлдвэрт техникийн шинэчлэл хийсний дээр шинээр 40 айлын орон сууцыг ашиглалтанд авч, гэр хорооллыг цэвэр усны сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлснээр олон арван айл өрхийн амьдралын нөхцөл сайжирсан байна.

6. Үйлдвэрлэлийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2009 онд аймгийн Засаг даргаас төсвийн захирагчид, менежерүүд, аж ахуйн нэгжийн дарга эрхлэгчидтэй байгуулсан гэрээнд бодит үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр буй болгох асуудлыг нэг гол шалгуур үзүүлэлт болгон оруулж, хэрэгжилтийг нь хянаж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ